



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 27 өдөр

Дугаар А/151

Бат-Өлзий сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах тайлагнах журам”-ын 3.5.7, 3.6.1, 3.6.16 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах сангийн зөвлөлийн 2022 оны 09 дүгээр сарын 25-ний өдрийн 05 дугаар хурлын шийдвэрийг үндэслэн нийтийн эзэмшлийн талбай болон ногоон байгууламжид тарьсан мод бутны арчилгааны ажлын хөлсний зардалд 472,500 (дөрвөн зуун далан хоёр мянга таван зуун) төгрөг, хөдөлмөр хамгааллын хэрэгслийн зардалд 495,000 (дөрвөн зуун ерэн таван мянган) төгрөг, хууль бус мод бэлтгэлээс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлын хяналт шалгалтын шатахууны зардалд 3,296,095 (гурван сая хоёр зуун ерэн зургаан мянга ерэн таван) төгрөг, бичиг хэргийн зардалд 176,750 (нэг зуун далан зургаан мянга долоон зуун тавин) төгрөг, нийт 4,440,345 (дөрвөн сая дөрвөн зуун дөчин мянга гурван зуун дөчин таван) төгрөгийг зарцуулсугай.

2. Зардалд шаардагдах 4,440,345 (дөрвөн сая дөрвөн зуун дөчин мянга гурван зуун дөчин таван) төгрөгийг Байгаль хамгаалах сангаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын Санхүүгийн албаны дарга (О.Отгонтуяа)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН

622202311

C:\My Doc A-4 zahiramj /Zasag darga/